

2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөг орчууллаа

ОХУ-ын төмөр замын тээврийн салбарын 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөг орчуулж, орчуулгыг нэгтгэн хянасан. Стратеги төлөвлөгөөнд:

Олон улсын харилцаанд хууль эрх зүйн нэгдсэн орон зайг бий болгох, зорчигч болон ачаа тээвэрлэлтийн технологийг сайжруулах, тээврийн хууль тогтоомжуудыг нийцүүлэх зорилгоор олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох;

Төмөр замын сүлжээг хөгжүүлэх хамтын стратеги боловсруулах, эдгээр орнуудын эдийн засагт тээврийн ачааллыг бууруулах, 1520 мм царигтай төмөр замын тээврийн нэгдсэн технологийн давуу талыг хөгжүүлэх, дэвшилтэт технологи боловсруулан нэвтрүүлэхэд чиглэсэн 1520 мм-ийн царигтай улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх;

Олон улсын тээврийн зах зээл дээр төмөр замын үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаадын тээврийн компаниудын хөрөнгө оруулалтад оролцох, гадаадын түншүүдтэй хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, харилцан ашигтай нөхцөл байдал үүсгэх;

Олон улсын тээврийн коридорыг хөгжүүлж, ОХУ-ын төмөр замын дамжин өнгөрөх боломжийг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаанууд 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Зорчигчдын сэтгэл ханамжийг тодорхойлох судалгаандаа дүгнэлт гаргав

Зорчигч тээврийн вагоны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор зорчигчдын сэтгэл ханамжийн нарийвчилсан судалгаа гаргаж вагоны үйлчилгээний стандартыг сайжруулах цаашдын үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг гаргах эх сурвалж болгох үүднээс энэхүү санал асуулгыг 2017 оны 02 сарын 23-24-ний өдрүүдэд судалгааны баг томилогдон ажилласан. Зорчигчтой анхдагч харилцааг тогтоон, суурь шинжтэй мэдээллийн бааз бүрдүүлж ажиллахын зэрэгцээ тээвэрлэлтийн орчин, зорчигчдын сэтгэгдэл, үйлчилгээний чанар зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь судалж мэдээллийг ажиглалт, санал асуулга, ярилцлага, статистик мэдээллийн аргуудаар цуглуулан боловсруулсан болно.

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн Төрийн байгууллагад ажилладаг 26-40 насны эмэгтэйчүүд хамгийн их хувийг эзэлж байна. Аль нэг тээврээр (төмөр замын тээвэр, авто тээвэр) зорчиход тасалбарын үнэ, цаг хугацаа чухал биш нь судалгаанаас харагдлаа. Учир нь судалгаанд оролцогчидын 69% нь авто тээвэр ба галт тэргээр зорчихдоо тасалбарын үнийг боломжийн гэж үзсэн бол 54% нь аюулгүй байдлыг харгалзан үзэж зорчдог гэж хариулсан байна.

Нас	-25	26-40	41+	Хүчингүй	Нийт
Хүйс					
Эр	17%	18%	6%	4%	41%
Эм	19%	27%	9%		55%
Нийт	36%	45%	15%		
Ажилладаг байгууллага					
Төрийн бус байгууллага	5%	5%	2%		12%
Төрийн байгууллага	6%	23%	5%		34%
Аж ахуй нэгж байгууллага	6%	9%	3%		18%
Ажил эрхлээгүй	10%	2%	4%		16%
Бусад	9%	8%	3%		20%
Нийт	36%	47%	17%		100%



ТӨВИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАГААР ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА:

Салбарын спорт өдөрлөгийн бэлтгэл ажил хийгдэж байна



Энэхүү тэмцээний зорилго нь Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг спортын тэмцээний бэлтгэл ажлын хүрээнд Төвийн ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны нөхөрсөг харилцааг бэхжүүлэх, шилдэг баг, тамирчдыг шалгаруулахад оршино. 2017 оны 03.27-03.31-ны хооронд удирдамжийн дагуу тэмцээн зохион байгуулж аваргаа шалгарууллаа.

“УБТЗ” ХНН-ийн Түүхийн музейтэй



Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтсээс зохион байгуулсан Төвийн мэдээллийн цагаар УБТЗ-ын Түүхийн музейтэй Төвийн хамт олон танилцлаа. Тус музейг УБТЗ-ын техник мэдээллийн ордны дэргэд 1970 онд анх байгуулагдсан бөгөөд 1983 оны 8 дугаар сарын 5-нд буюу төмөр замчдынбаярынөдрийгтохиолдуулан музейг шинэчлэн нээсэн байна.

ТЭЭВЭРЛЭЛТИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



Зорчигч тээвэрлэлт 2017 оны гуравдугаар сард 230.0 мян.зор тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 11.4%-аар өссөн, ачаа тээвэрлэлт нь 2017 оны гуравдугаар сард 1636.2 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Дамжин өнгөрсөн ачаа /тонноор/



Дамжин өнгөрсөн ачаа 2017 оны гуравдугаар сард 220264.3 тн ачсан нь өнгөрсөн оны мөн үеэс 16491.6 тн буюу 8.09 хувиар өссөн байна.

2017 оны эхний гурван сард ачилт 3799.85 мян.тн өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11.2% өссөн, гуравдугаар сард ачилт 1339.8 мян.тн буюу өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14.6% өссөн үзүүлэлттэй байна.

АЧИЛТ- АЧААНЫ ТӨРЛӨӨР







Төмөр замын тээврийн салбарын шинэ технологи, Ноу Хау-г судалж байна

Олон улсын төмөр замын байгууллагаас эрхлэн гаргадаг төмөр замын холбогдолтой олон улсад нэр хүнд бүхий сэтгүүлүүдийг захиалан төмөр замын тээврийн салбарын шинэ техник, технологи ноу хауг судалж байна. Тус сэтгүүлүүдийн цахим хувилбартай манай байгууллагын веб хуудсаар дамжуулан үнэгүй танилцах боломжтой. <http://rtcc.mrtd.gov.mn/>

2017 оны 3 дугаар сарын дугаарууд



ХОЛБОО БАРИХ



Утас: +976 77244403



Факс: +976 7724 4403



Веб: rtcc.mrtd.gov.mn

https://twitter.com/rtcc_mn



<https://www.facebook.com/rtcc.mon/>



И-мэйл: info@rtcc.mrtd.gov.mn



Хаяг: “Хан-Уул” цамхаг,
Б.Шаравын гудамж 6, 3-р хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс